

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН 29-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХҮНИЙ ЭРХИЙН ДЭД ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХҮНИЙ ЭРХИЙН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4 - 21

1. Хүний эрхийн дэд хорооны 2024-2025 онд хийх ажлын
төлөвлөгөө батлах тухай

5 - 21

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Хүний эрхийн дэд хорооны 10 дугаар сарын 29-ний өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хүний эрхийн дэд хорооны дарга С.Эрдэнэболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 10 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 70.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 14 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

*Томилолттой: П.Сайнзориг, Г.Уянганхишиг;
Тасалсан: Ц.Сандаг-Очир.*

Нэг.Хүний эрхийн дэд хорооны 2024-2025 онд хийх ажлын төлөвлөгөө батлах тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Хүний эрхийн дэд хорооны 2024-2025 онд хийх ажлын төлөвлөгөөг Хүний эрхийн дэд хорооны дарга С.Эрдэнэболд танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, О.Номинчимэг нарын тавьсан асуултад Хүний эрхийн дэд хорооны дарга С.Эрдэнэболд хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

С.Эрдэнэболд: Хүний эрхийн дэд хорооны 2024-2025 онд хийх ажлын төлөвлөгөөг батлах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 3
Бүгд: 7

57.1 хувийн саналаар ажлын төлөвлөгөө батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Х.Баасанжаргал нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 85.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Уг асуудлыг 15 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Дэд хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 45 минут үргэлжилж, 10 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 70.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 59 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХҮНИЙ ЭРХИЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА

С.ЭРДЭНЭБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
15 цаг 14 минут

ХҮНИЙ ЭРХИЙН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Эрдэнэболд: Өнөөдөр 2024 оны 10 сарын 29-н нийслэлийн ойн өдөр байна.

Хүний эрхийн дэд хорооны 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааныг эхэлснийг мэдэгдье.

Хүний эрхийн дэд хорооны гишүүдийн ирц 10 байхаас одоогоор 6 байна.

Тэгэхээр хуралдаан хүчин төгөлдөр эхлэх боломжтой болж байна.

Ингээд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу ирцийг заавал танилцуулах ёстой.

Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн, Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн, Одсүрэнгийн Номинчимэг гишүүн, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн, Даваагийн Цогтбаатар ирж байгаа гэсэн. Сүхбаатарын Эрдэнэболд.

6 хүний бүрэлдэхүүнтэй байна.

Ирц бүрэн хангалттай учраас хуралдаан эхэлснийг мэдэгдье. /алх цохив/

Хүний эрхийн дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Та бүхэнд танилцуулъя.

Нэгдүгээрт, Та бүхэнд тарааж өгсөн байгаа.

Хүний эрхийн дэд хорооны 2024-2025 онд хийх ажлын төлөвлөгөөг батлах тухай ийм асуудал байгаа.

Хэлэлцэх асуудлыг тарааж өгсөн. Энэ дээр саналтай дэд хорооны гишүүд байна уу?

Танилцуулаад явж байя. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байхгүй юу? Тийм ээ. Тэгвэл хэлэлцэх асуудлыг баталъя.

Нэг.Хүний эрхийн дэд хорооны 2024-2025 онд хийх ажлын төлөвлөгөө батлах тухай

Эхлээд ажлын төлөвлөгөөнөөс өмнө Та бүхнийг дэлгэц рүү анхаарлаа хандуулахыг хүсэж байна.

Нөгөө презентациаа эхлүүлчих.

Ер нь Хүний эрхийн дэд хороо ер нь ямар үүрэгтэй функцтэй, бид нараас ер нь ямар ажлын хүлээлтүүд байгаа. Бид ер нь дүрэм, журмын хүрээнд, хуулийн хүрээнд ямар ямар ажлуудыг зохих ёсоор хийх ёстой талаарх мэдээллийг бэлтгэсэн байгаа.

Мэдээж Улсын Их Хурлын яг энэ Хүний эрхийн дэд хороо байгуулагдсан цагаасаа хойш яаж ажиллаж ирсэн, хэчнээн удирдлагууд ажиллаж байсан юм, ямар ямар тушаал, шийдвэрүүд гаргаж байсан, дүгнэлтүүд гаргаж байсантай холбоотой статистикийг бэлдсэн байгаа.

Энэ гарч байгаа нь Э.Бат-Үүл дарга, Х.Тэмүүжин, Д.Ганбат, Ё.Отгонбаяр, Л.Болд, Дамдины Цогтбаатар, Наваан-Юндэнгийн Оюундарь, Б.Энхбаяр, Ц.Мөнхцэцэг гэсэн. Одоогоор С.Эрдэнэболд гэхээр 10 дахь нь юм байна.

Ингээд өмнө нь 9 Улсын Их Хурлын гишүүд дэд хорооны даргаар ажиллаж байсан юм байна.

Дараагийнх нь тэгээд энэ болохоор өнгөрсөн хугацаанд ер нь Хүний эрхийн дэд хороо хэчнээн удаагийн хурал хийсэн юм, ямар ямар

шийдвэрүүд гаргасантай холбоотой товч статистикийг бүрдүүлсэн байгаа.

Тэгээд parliament.mn дээр Хүний эрхийн дэд хорооноос хуралдсан хуралдааны тэмдэглэлүүд орсон байдаг юм билээ.

2010 оноос хойш статистикууд харагдаж байна.

Ингээд 2017 он, 2018 он, 2019 он, 2021, 2024 он гээд.

Ер нь жилдээ нэг, хоёр удаа л ер нь Хүний эрхийн дэд хороо хуралдаад л явсан юм байна лээ.

Ингээд энэ бол зүгээр товч танин мэдэхүйн мэдээлэл харуулж байгаа юм.

Учир нь энэ Хүний эрхийн дэд хороон дээр өмнө нь хийж байсан ажлууд Монгол төр ой санамжтай байх ёстой учраас өмнө нь ямар ямар асуудлууд дээр яаж хандаж байсан юм, Хүний эрхийн Үндэсний Комисс болон хүний эрхийг хамгаалах чиглэлийн төрийн бус байгууллагуудтай хэрхэн харилцаж байсан. Мөн олон улсын байгууллагууд, гадаад орны Элчин, дипломат газруудтай яаж харилцаж байсан. Мөн Засгийн газрын байгууллагууд, судалгаа, шинжилгээний хүрээлэнгүүдтэй харилцаж ямар судалгаа захиалгаар хийлгэж байсан. Түүнийгээ Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд оруулж яаж шийдвэр гаргахад оруулж байсан тухай мэдээллүүдийг энэ статистикаас харуулж байгаа.

Д.Цогтбаатар Хууль зүйн байнгын хорооны даргын хувьд өмнө нь дэд хороон даргаар ажиллаж байсан.

Д.Цогтбаатар дарга аа, өмнө нь Хууль зүйн байнгын хорооны Хүний эрхийн дэд хорооны талаарх нэг товч мэдээлэл өгсөн.

Энд ямар ямар дарга нар ажиллаж байсан, хэчнээн хурал хийсэн, ямар шийдвэрүүд гаргаж байсан, ямар дүгнэлтүүд гаргаж байсан. Тэр нь цаашаагаа яаж ажил хэрэг болсонтой холбоотой энэ товч статистик мэдээллүүдийг үзүүлж байгаа юм.

Ер нь бид үүнийгээ ингээд нэг цэгцлээд авахгүй бол бас мэдээллүүд маш их цэгц муутай байдаг юм байна.

Архивлагдсан зүйлүүд нь хомс. Зарим нь цахим архивт байхгүй. Зарим нь цаасан архивд байхгүй байдаг юм байна.

Тэгэхээр өнгөрсөн хугацаанд Хүний эрхийн дэд хорооны ажлуудын ер нь тушаал, шийдвэр, гарч ирсэн бүх зүйлүүдийг нэг эрэмбэлээд цэгцлээд нэгдсэн ийм архив болгож авах нь бид нарт тустай.

Цааш цаашдаа ч гэсэн хэн энэ дэд хороог ахлахаас үл шалтгаалж ямар шийдвэрүүд гарч ирсэн бэ гэдэг дээр бид анализ хийж, дараа дараагийнхаа ажил, хамтын ажиллагаандаа хэрэг болох болов уу гэдэг энэ ажлыг Г.Золжаргал бид хэд эхлүүлчихсэн явж байгаа.

Одоо ингээд хэлэлцэх асуудлын үндсэн асуудал болсон 2024, 2025 оны төлөвлөгөөгөө Та бүхэнд танилцуулъя.

Г.Тэмүүжин гишүүн.

Г.Тэмүүжин: Үнэхээр архивт мэдээ баримтыг нэлээн сайн нягтлахгүй бол жишээ нь Хүний эрхийн дэд хорооны чинь хамгийн мундаг хийсэн ажил 2009 оны 12 сард 2008 оны 7 сарын 01-тэй холбоотой хүний эрхийн зөрчлөөр сонсгол хийсэн байхгүй юу. Жишээ нь.

Тэгээд тэндээс маш олон дүгнэлтүүд, шийдвэрүүд гараад, зөвлөмжүүд гараад, тэр зөвлөмжийн дагуу нэг том ажил эхэлж байсан. Гэх мэтчилэн. Тийм баримтууд бас байгаа шүү.

Монгол Улсын Их Хурлын түүхэнд анхны нээлттэй сонсголыг зохион байгуулж байсан тохиолдол.

С.Эрдэнэболд: Баярлалаа.

Тэгэхээр одоо намайг оруулах юм бол одоо мэдэгдэж байгаагаар дэд хороог 11 Улсын Их Хурлын гишүүн даргалж байсан юм байна.

Тэгэхээр үе үеийн дэд хорооны даргаар ажиллаж байсан хүмүүстэй уулзалт хийхээр төлөвлөж байгаа.

Зарим мэдээллүүд нь цоохор алаг, байхгүй байгаа учраас одоо жишээлбэл Ц.Мөнхцэцэг гишүүн, Б.Энхбаяр гишүүн, Д.Цогтбаатар гишүүн гээд хүмүүстэй уулзаад яг тухайн дэд хороог ахалж байхдаа гол зарчим барьж байсан зүйлүүд, шийдлүүд гэдэг дээр нь бид ингээд мэдээллийг нөхөж авах, архивлах ажлыг хийнэ.

Тэр утгаараа Г.Тэмүүжин гишүүний ярьж байгаа зүйлийг ч гэсэн оруулаад үүнийгээ бас нэг тийм төрийн ой санамжид архивлаад нэг цэгцэлье гэсэн бодолтой байгаа.

Тэгээд оноос өмнө энэ ажлыг хийгээд 12 дугаар сард Та бүхэнд бас танилцуулъя гэж бодож байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Хэлэлцэх асуулттай холбоотой асуулттай гишүүн байхгүй гэсэн. Тийм ээ. Түрүүн.

Асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна.

Тэгвэл дэлгэц дээр хэлэлцэх асуудлынхаа танилцуулгыг харуулчихъя.

Цаасаар тарааж өгсөн байгаа. Бас цахимаар явуулсан байгаа.

Энэ яах вэ ингэсэн юм. Бид өмнөх дэд хороонуудын ажиллаж байсан зүйлүүдийг Их Хурлын Тамгын газрын архиваас судалж шүүж үзсэн. Нэг.

Хоёрдугаарт, энэ дэд хорооны даргаар ажиллаж байсан зарим Улсын Их Хурлын гишүүдтэй уулзаж үзсэн.

Мөн өнгөрсөн хугацаанд, өнгөрсөн долоо хоногт үндэс Хүний эрхийн Үндэсний Комиссынхонтой 2 цаг 30 минутын уулзалт хийж, ер нь Хүний эрхийн дэд хорооноос Та бүхэн ямар хүлээлттэй, шийдвэр гаргалт ямар хүлээлттэй байгаа талаар нэлээн нухацтай асуусан.

Ингээд хүний эрх зөрчигдөж байдаг гэх хардлага төрдөг тиймэрхүү газруудын холбогдох удирдлагуудтай уулзаад өнөөдрийн хуралдаандаа бид бэлтгэсэн юм.

Ингээд жоохон тулгуу өгч байгаад уучлаарай.

Тэгээд Хүний эрхийн дэд хорооны даргаар ажиллаж байсан Ё.Отгонбаяр гишүүний үед яг ийм хөтөлбөр хийж байсан юм билээ.

Тэгэхээр бидэнд архиваас олдож байгаа ганц зүйл нь Ё.Отгонбаяр гуайн дэд хорооны даргаар ажиллаж байх үеийн яг ийм нэг төлөвлөгөө байгаа.

Бусад дарга нарынх харьцангуй олдохгүй байгаад байгаа.

Тэгээд нэг бүрчлэн уулзахдаа энэ талаар мэдээллийг ингэж бүрдүүлж авъя гэсэн бодолтой байгаа.

Тэгээд тэр формат загварын дагуу ийм хөтөлбөр хийсэн байгаа.

Нэгдүгээрт нь, би ингээд танилцуулна. Ард талд нь Улсын Их Хурлын гишүүдийн яг тодорхой танилцуулаад дуусангуут нь би энэ ажил дээр нь илүү идэвх зүтгэлтэйгээр хариуцаж ажиллая гэсэн саналуудыг нь тусгаад тэгээд та бүхний саналуудыг оруулаад хөтөлбөрөө батлаад явна.

Нэгдүгээрт нь, бид маргааш Цагдан хорих 461 дүгээр хаалттай хорих анги дээр ажиллахаар байгаа.

Шүүхээс зөвшөөрөл нь гарчихсан. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай холбогдоод ном журмын дагуу бүх бичиг баримтууд нь болчихсон байгаа.

Тэгээд ер нь зөвхөн 461 дүгээр хорих анги төдийгүй бусад хорих ангиуд, эмэгтэйчүүдийн хорих анги, хүүхдийн хорих анги гээд бусад хорих ангиудаар орж ажиллах юм байна. Энэ ингээд нэгдүгээрт байна.

Хоёрдугаарт нь, Хүний эрхийн дэд хороотой холбогдуулаад, сэтгүүлч Н.Өнөрцэцэгтэй холбогдуулж маш олон хүмүүсийн гомдлууд ирж байгаа.

Энэ дээр 6 хоногийн өмнө би дэд хороон дарга болсноос хойш нийт ирж байгаа, хандаж байгаа мэдээллүүдийн бараг 70 хувь нь дангаараа сэтгүүлч Н.Өнөрцэцэгтэй холбоотой асуудал, шүүх хурлыг нээлттэй явуулах тухай асуудал ирж байгаа учраас бид энэ асуудал дээр хандаж байгаа.

Мөн нөгөө хэлмэгдсэн гээд байгаа хүмүүс байгаа. Ил тод, олон нийтийн дуулиан шуугианд өртөөгүй ч гэсэн яг ингээд чимээгүй хэлмэгдлийн нөхцөл байдалтай байгаад байгаа тийм кэйс хэргүүдийг бид Хүний эрхийн Үндэсний Комиссоос лавлагаа судалгааг нь авч байгаа.

Тэгээд зөвхөн нийгэмд анхаарлын төвд байгаагаас гадна анхааралд өртөхгүй байгаа хэргүүд дээр ч гэсэн бид хүрч очиж ажиллаж кэйс статус хийх ёстой болов уу гэж бодож байгаа.

Гуравдугаарт нь, Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүн тус бүрийн үйл ажиллагаатай танилцах, санал, дүгнэлт боловсруулах гээд энэ ажлыг 11 дүгээр сарын 04-ний өдрийн 11.00 цагаас 18.00 цагийн хооронд бүтэн 7 цаг яг 7 гишүүнтэй нэг бүрчилж уулзаж, тухайн гишүүний хариуцаж байгаа кэйс болгон дээр нь бид мэдээлэл авах энэ ажлыг төлөвлөгөөнд оруулсан байгаа.

Дөрөвдүгээрт, Улсын Их Хурал түүний Тамгын газрын бодлого, үйл ажиллагаа хүний эрхэд суурилсан талаар аливаа шийдвэр гаргахдаа хүний эрхэд нөлөөлөх байдлыг хэрхэн хангаж байгаа талаар судалгаа шинжилгээ, санал,

дүгнэлт боловсруулах гээд Улсын Их Хурлын Тамгын газартай бас энэ талаар хамтарч ажиллаад уулзалтуудыг хийсэн байгаа.

Тамгын газрын холбогдох хүмүүстэй уулзаад судалгаагаа бид хүсэлтээ өгчихсөн байж байгаа.

Тавдугаарт нь, хүний эрх, эрх чөлөөг хангах тогтолцооны өнөөгийн нөхцөл байдал, Хүний эрхийн дэд хороо, Хүний эрхийн Үндэсний Комиссын ажлын уялдаа холбоог бэхжүүлэх талаар санал, дүгнэлтийг боловсруулах төлөвлөгөө оруулсан байгаа.

Эндээ мэдээлэл солилцох механизмыг яаж сайжруулах вэ, энэ дотроо цахим платформ ашиглан мэдээлэл солилцох, хамтран ажиллах боломж нөхцөлийг бүрдүүлэх, тогтмол хамтарсан судалгаа, тайлан хийх чиглэл байгаа.

Мөн хяналт, үнэлгээний системийг бий болгох тал дээр Хүний эрхийн Үндэсний Комисс талын саналыг сонссон.

Энэ дээрээ Хүний эрхийн дэд хорооны гишүүдийн саналыг нэмж авна.

Мөн Хууль зүйн байнгын хорооноосоо ч гэсэн гишүүдээсээ саналаа авахаар байгаа.

Зургадугаарт нь, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хяналт шалгалт хийх, холбогдох санал, дүгнэлт боловсруулах гээд нэлээн өргөн хүрээтэй ажлууд байгаа.

Энэ бол дүүрэг, хорооноос гэр бүлийн орчин дахь хүүхдийн

хүчирхийлэл маш өндөр статистиктай байдаг юм байна.

Энэ дээр бас урьдчилан сэргийлэх ямар арга хэмжээ авч байх талаар судалгаа, түүнийг хэрэгжилтийг нэгтгэн гаргуулах. Энэ дээр тодорхой дүүргүүд, тодорхой байршлууд дээр Хүний эрхийн дэд хорооны гишүүдийн хамтаар очих энэ ажлууд байгаа.

Эрүүл мэндийн байгууллагад гарч байгаа хүүхдийн эрхийн зөрчлийн талаарх өргөдөл, гомдол, тэдгээрийн шийдвэрлэлтийн талаарх статистик тоон мэдээллийг бэлтгэн гаргуулах чиглэлийг анхаарч ажиллана.

Мөн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын байгууллагуудад гарч байгаа хүүхдийн эрхийн зөрчил, шийдвэрлэлт, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар мэдээллийг боловсруулах гэж байгаа.

Энэ дээр өмнө нь Хүний эрхийн Үндэсний Комисс дээр Улсын Их Хурлын даргыг ажиллаж байхад Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн яг үе тэнгийн дээрэлхэлттэй холбоотой мэдээллүүдийг хэлж байсан учраас үүнийг нь тусгай зорилт болгож төлөвлөгөөндөө оруулсан байгаа юм.

Долоод нь, Сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын байгууллагын хичээлийн хөтөлбөрт хүний эрхийн талаарх агуулгыг хэрхэн тусгаж ажиллаж байгаа талаар, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, дүгнэлт боловсруулах, шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх саналыг боловсруулах гэж байгаа.

Энэ дээр холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийлгэх, мөн холбогдох төрийн захиргааны төв байгууллагын саналыг авах, зарим сургууль, цэцэрлэг дээр тандан судалгаа хийх гэсэн энэ хөтөлбөрт оруулж байгаа.

Наймдугаарт нь, хүний эрх, эрх чөлөөг түгээн дэлгэрүүлэхэд олон нийтийн сан санаачилгыг идэвхжүүлэх, Human Right үндэсний цахим платформыг бүтээх, хөгжүүлэх, Хүний эрхийн дэд хорооны цахим хаяг нээх, хөгжүүлэх ийм зүйлүүд байна.

Энэ дээр яаж байна гэхээр Их Хурлын Тамгын газраас ажиллуулж байгаа 2 платформ байгаа. Нэг нь болох юм бол D-Parliament, нэг нь petition байгаа.

Тэгэхээр D-Parliament болохоор ерөнхийдөө одоо нөгөө хуулийн төсөлтэй холбоотой холбоотой санаануудыг авчихдаг. Petition болох юм нөгөө 100 мянга гаруй үсэг ч гэдэг юм уу, тодорхой нийгэмд дуулиан шуугиан болсон асуудлууд дээр иргэдийн гарын үсэг цуглуулах платформ байгаад байдаг.

Тэгэхээр энэ дээр бид Улсын Их Хурлын Тамгын газар дээрээс яг Улсын Их Хурал дээр ирж байгаа өргөдөл, гомдлын хэчнээн хувь нь жишээлбэл хүний эрхийн зөрчилтэй холбоотой зүйлүүд байна вэ.

Мөн хууль шүүхийн байгууллагуудаас жишээлбэл цагдаагийн байгууллага ч гэдэг юм уу. Ингээд холбогдох бүтцийн байгууллага. Нөгөө талаасаа бас Хүний эрхийн Үндэсний Комисс дээр ирж байгаа энэ өргөдөл, гомдлыг гэдэг бид системийнх нь хувьд

цэгцэлж нэгдсэн ийм платформ дээр харах нь маш чухал байгаа.

Өөрөөр хэлбэл цахим уялдаа холбоог сайжруулах. Нөгөө талаасаа бид залуучуудын, ялангуяа хүн амын дийлэнх масс болсон залуучуудын, өсвөр үеийнхний дунд хүний эрхийн мэдрэмжтэй байх, мэдлэгийг түгээхэд онлайн респонсив платформуудыг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байгаад байгаа.

Тэгэхгүй бол одоо уламжлалт цаасан байдлаар ирж байгаа өргөдөл, гомдлууд маш их хугацаа авдаг. Иргэдэд хүндрэл учруулдаг.

Нөгөө талаасаа цахим хуудас руу ордоггүй.

Их Хурлын Тамгын газраас ажиллуулж байгаа веб сайт руу иргэдийн орж байгаа илэрц маш бага байдаг юм билээ.

Тэгээд тэр утгаараа үүнийг илүү иргэдэд ойрхон, хүртээмжтэй, хүндрэл багатай, нэгдсэн ийм сан бүрдүүлэх ажил дээр Тамгын газар дээр санал тавиад энэ дээр хамтарч ажиллая гээд явж байна.

Есдүгээрт нь, хууль тогтоомжийн хэрэгжилт хяналт тавих байнгын ажиллагаатай ажлын хэсэг байгуулах талаар зүгээр санал бол нээлттэй байгаа.

Монгол Улсын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон “Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолд гэрч, хохирогчийг хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах алба шинээр байгуулж, хохирогчийн эрхийг хангах, хохирол барагдуулах үйл

ажиллагааг шинэ шатад гаргана гээд тусгасан байгаа.

Энэ бол манай Хууль зүйн байнгын хороон дээр анхаарал татаж байгаа ажил.

Үүнийг бид энэ дээр жишээлбэл Хүний эрхийн дэд хороон дээр яаж ажил хэрэг болох дээр нь бид дэмжлэг үзүүлж хамтарч ажиллах вэ гэдгийг хөтөлбөртөө оруулсан байгаа.

Аравдугаарт нь, эрүүдэн шүүлттэй холбоотой хэрэг хянан шийдвэрлэх тусгай нэгж байгуулах хэрэгцээ шаардлага, боломж нөхцөлийн талаар судалж холбогдох санал, дүгнэлтийг боловсруулах, судалгааны байгууллагаар холбогдох, харьцуулсан судалгаа хийлгэх, хэлэлцүүлгүүд зохион байгуулах, мөн эрүүдэн шүүлт, хүнлэг бус хэсгийн хандалтад өртсөн талаарх иргэдийн өргөдөл, мэдээллийн шийдвэрлэлтийн талаар санал дүгнэлт боловсруулах гээд.

Энэ дотроо тодорхой хууль хяналтын байгууллагууд, эрүүл мэндийн байгууллага, боловсролын байгууллага, дээрээс нь ахмад настны асрамжийн төвүүд гэх мэт. Цэргийн анги. Одоо нөгөө хорих анги ч гэдэг юм уу. Тийм ээ. Эдгээрийг багтаасан ажлыг явуулья гэж байгаа.

Арван нэгдүгээрт нь, хилс хэрэгт хэлмэгдэж улмаар шүүхээр цагаадагдсан иргэдийн талаар судалгаа гаргаж, уулзах, холбогдох санал дүгнэлт боловсруулах гэдгийг анхааралдаа авч үзэх ёстой юм байна гэж.

Та бүхэн анзаарсан бол сая хүн амины хэрэгт хилсээр гүтгэгдээд 15 жил

болсон залуугийн энэ социалаар мэдээ мэдээллүүд яваад байгаа.

Тэгээд энэ асуудлаар бид холбогдох байгууллагаас асуухаар тодорхой мэдээлэл өгөх боломжгүй, бүртгэлгүй байгаад байгаа юм.

Тэгэхээр гэх мэт бид зүгээр ингээд нийгэмд скандал болж байгаа асуудлуудаас гадна өөрсдөө яг энэ чиглэлээр санаачилгатай, далд байгаа асуудлуудыг ил гаргаж ирэх дээр дүрэм журмын дагуу ажиллах нь манай хөтөлбөрт тусгагдах ёстой юм болов уу гэж бодож байна.

Арван хоёрдугаарт нь, хилийн чанадад амьдарч байгаа монгол иргэдийн хүний эрхийн нөхцөл байдлын талаарх энэ санал, дүгнэлтийг боловсруулах хэрэгтэй байна.

Мэдээж энэ сонгох, сонгогдох эрхийн асуудал. Тэгээд дээрээс нь энэ хүний наймаатай холбоотой, шударга бусаар хөдөлмөрөө хүмүүжүүлж байгаа ч гэдэг юм уу, маш олон иргэдийн гомдлууд байгаа.

Тэгээд сая жишээлбэл Сан Франциско хотод байдаг Консулын газрын үйл ажиллагаатай танилцах явцад энэ чиглэлээр иргэдийн гомдлууд их ирдэг юм байна.

Гэхдээ энэ нь ингээд шийдвэрлэхэд маш их удаан хугацаа туулдаг. Тухайн байгаа улсынхаа хууль, дүрэмтэй холбогдуулаад эрхээ хамгаалуулж чадахгүй, хууль зүйн туслалцаа авч чадахгүй байдлууд их гардаг юм байна лээ.

Тэгэхээр энэ дээр бид энэ Монгол Улсын Их Хурал юм чинь энэ дээр бид

анхаарал хандуулж байх нь зөв байх гэж бодож байна.

Арван гуравдугаарт нь, Эрүүгийн болон бусад зарим хууль тогтоомжуудад хүний эрхийн чиглэлээр дүн шинжилгээ хийж, санал, дүгнэлт боловсруулах гээд.

Энд нь процессын хуулиудыг нь ард нь дурдсан байгааг Та бүхэн харж байгаа.

Арван дөрөвт нь, Хүний эрхийн Үндэсний Комиссын эрхийн төлөв байдлын илтгэлийг Улсын Их Хурал хаврын чуулганаар хэлэлцдэг.

Үүнтэй холбогдуулж Улсын Их Хурлын тогтоолуудын хэрэгжилтэд хяналт тавих, санал, дүгнэлт боловсруулахад бид санаачилгатай ажиллах нь зөв болов уу.

Гэхдээ энэ бол зөвхөн Хүний эрхийн дэд хороо талаасаа, Хууль зүйн байнгын хорооны талаасаа бид энэ дээр нэлээн нягт ажиллах нь зөв юм болов уу гэж бодож байна.

Арван тавдугаарт нь, иргэний боловсролыг дэмжих хүрээнд хувь хүний эрх чөлөө, ардчилал, чөлөөт эдийн засаг, хуулийн засаглал, Үндсэн хуулийн байгуулалтын байгуулалтын ач холбогдлыг таниулах хөтөлбөр хэрэгжүүлэх гээд.

Энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрт орчихсон байгаа.

Энэ дээр бид бас энэ Хууль зүйн яам, Хүний эрхийн Үндэсний Комисс болон мэдээж Хууль зүйн байнгын хороогоороо үүнийг тодорхой ажил хэрэг болгоод бид энэ дээр нь анхаарал ач холбогдол өгөөд явах юм бол зөв болов

уу гээд хөтөлбөрт тусгахыг санал болгож байгаа.

Арван зургаад нь, Үндэсний олон нийтийн телевиз бол олон нийтийн телевиз гэдэг утгаар нь бид Хүний эрхийн дэд хорооны санаачилгаар, мөн Хууль зүйн байнгын хорооны ийм тусгай нэвтрүүлгүүдийг өргөн нэвтрүүлдэг цагтай больё гэдэг энэ саналыг хөтөлбөртөө оруулж байгаа юм.

Тэгээд сонгогчдод энэ хүний эрхийн талаарх мэдлэг, мэдээллийг тогтмол хүргэдэг улирал тутмын ийм нэвтрүүлгүүдийг хийдэг байя гэсэн ийм саналыг оруулж байгаа.

Энэ дээрээ яг энэ Хууль зүйн байнгын хороо, тэр тусмаа Хүний эрхийн дэд хорооноос хийж байгаа ажлуудаа манай Хүний эрхийн дэд хорооны 10 гишүүн болон Хууль зүйн байнгын хорооны гишүүд, мөн саналтай Байнгын хороонд ороогүй Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн оролцоод энэ асуудал дээрээ өргөн нэвтрүүлэгийн сувгаар тогтмол нэвтрүүлгүүдийг бэлдэж гаргадаг байя гэсэн ийм бодолтой байгаа.

Тэгэхгүй болохоор ер нь нэг ийм дуулиан шуугиан, сошиалын скандал дагадаг гэхээсээ гадна бид бас явуулж байгаа бодлогоо, хөтөлбөрөө ч гэсэн олон нийтэд хүртээмжтэйгээр хүргэх тал дээр их дутмаг байдаг юм байна.

Яагаад гэхээр өнгөрсөн хугацаанд яг энэ хүний эрхийн боловсрол олгох чиглэлийн контент буюу нэвтрүүлгүүдийн хүртээмж маш бага байсан юм байна.

Хүний эрхийн Үндэсний Комиссоос стандарт хэвлэлүүд, олон

улсын санхүүжилттэйгээр гарч байгаа баримт бичгүүдийг хэвлэдэг юм байна.

Тэр нь тодорхой цөөн тоогоор хэвлэгдээд албан байгууллагуудад эд нар хүргэгддэг болохоос биш яг иргэд рүү очсон implementation буюу хэрэгжүүлэлт нь их сул.

Дээрээс нь үүнийгээ олон нийт рүү цацсан суваг сул байдаг юм байна.

Үндэсний олон нийтийн телевизээс гадна арилжааны телевизүүдтэй ярьж байгаад ер нь нийгмийн хариуцлагын хүрээнд хүний эрхийг дэмжигч гэсэн статусаар холбогдох дотор байгаа ажлын төлөвлөгөөнүүдээ задлаад жишээлбэл хүүхдийн эрхтэй холбоотой яг ингээд дагнасан нэвтрүүлгүүдийг нэг телевизтэй.

Тэгээд дээрээс нь эмэгтэйчүүдийн эрхтэй холбоотой ч гэдэг юм уу, ахмад настны эрхтэй холбоотой ч гэдэг юм уу. Гэх мэтээр үүнийгээ төрөлжүүлээд явах боломжтой юм байна гэж Хүний эрхийн Үндэсний Комисстой ярьсан байгаа юм.

Үнэнийг хэлэхэд Хүний эрхийн дэд хороо маань Хууль зүйн байнгын хороо маань ганцхан манай ГЗолжаргал ахлах зөвлөх л байгаад байгаа.

Яг одоогийн байдлаар референт ч юм уу, нарийн бичиг байхгүй байгаа.

Тэгэхээр яг одоогийн байдлаар нэг хүн дээр түшиглээд Д.Цогтбаатар даргатай ярьж байгаад энэ төлөвлөгөөний төслийг боловсруулж байгаа юм.

Ийм 16 зүйлийг эхний ээлжид оруулсан байгаа.

Харьцангуй цаасан дээр үлдэх биш амьдрал дээр хэрэгжих боломжтой зүйлүүд гэж үзэж байгаа.

Ингээд гишүүд Та бүхнийг үүнтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд эхлээд.

Дэгийн дагуу гишүүд гар өргөх биш кнопоо дарна. Асуулт. Тасаллаа.

Б.Бат-Эрдэнэ гишүүн,
О.Номинчимэг гишүүн. Б.Бат-Эрдэнэ гишүүн

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Хүний эрхийн дэд хороо маань чухал асуудлыг нэлээн нарийвчилсан стратегийн түвшинд авч үзэх гэж байгаа явдалд баяртай байна.

Энэ дээр 16 асуудал, 16 зүйл гэх юм уу, 16 агуулга гэх юм уу. Тийм ээ.

16 зорилтын хүрээнд хоёр юм байна.

Яах вэ, мэдээж үзэл бодлоо илэрхийлэх эрхийн зөрчилтэй холбоотой асуудлууд орчихсон байх шиг байна. Ялангуяа сүүлийн үед яах вэ манай зөвхөн Н.Өнөрцэцэгтэй холбоотой асуудлаас гадна давхар шүүхийн шатад явж байгаа хэвлэл мэдээллийн байгууллагуудын асуудлууд нэлээн байдаг юм шиг байна лээ.

Бид ер нь энэ хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой асуудлыг маш зөв гаргаж цаашдаа явуулах нь зөв байх.

Тэгэхээр үзэл бодлоо илэрхийлэх эрхийн зөрчилтэй холбоотой асуудал цаашаа уламжлаад нэлээн сайн түвшинд явах ёстой болов уу гэж харж байгаа.

Эрүүдэн шүүх, харгис хандах явдалтай холбоотой, энэ эрүүдэн шүүхтэй холбоотой асуудлууд байна.

Ер нь яах вэ, би нэг ийм хоёр саналыг л нэмж хэлэх гээд байгаа юм. Нэг нь энэ хөдөлмөр эрхлэлттэй холбоотой. Хөдөлмөрийн эрхийн зөрчил аягүй өндөр байгаа. Монгол Улсад.

Тэгэхээр энэ хөдөлмөрийн эрхийн зөрчлийг оруулж өгөх боломж юу билээ? Бид энэ барилгын салбарт ажиллаж байгаа, эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа, уул уурхайн салбарт ажиллаж байгаа хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлуудыг ер нь аюулгүй байдал, хөдөлмөрийн орчны стандартыг хангахгүй байгаа зөрчилтэй холбоотой асуудлууд, хүний эрхийнх нь асуудлуудыг хөндөхгүй бол бас их хэцүү.

Би Байгаль орчны сайдаар ажиллаж байсан. Энэ самарт явж байгаа иргэдийн асуудлууд их хүнд байдаг юм шүү дээ. Тэгээд нэг аж ахуйн нэгж нь самар авна гээд гэдэг. Орон нутгийн иргэдийг хөлсөлдөг. Тэгээд нөгөөдүүл нь очоод амь нас, эрүүл мэндийн аягүй том том асуудлууд үүсдэг жишээ бий.

Тэгэхээр хөдөлмөрийн эрхийн зөрчилтэй холбоотой асуудлуудыг хөндвөл их зөв юм болов уу. Нэмж.

Нөгөөдөх нь цахим орчинд хувийн мэдээллийн хамгаалалтын асуудал байна.

Сүүлийн үед цахим орчин нэлээн хөгжсөнтэй холбогдуулаад хувь хүний нууцтай холбоотой асуудлууд, хувийн мэдээлэлтэй холбоотой асуудлууд. Тэрийг нь эргээд хяналтгүйгээр ашиглахтай холбоотой хүний хувийн мэдээллийн эрхийг зөрчиж байгаа гэж үзэж байгаа юм.

Тэгэхээр энэ нь дэлхий дахинд нэлээн томоохон хэмжээний зөрчлүүд болж байгаа учраас хэдүүлээ Хүний эрхийн дэд хороон дээр Хүний эрхийн байгууллагуудын үүрэг дотор ч гэсэн ер нь зүгээр ийм төрлийн юмнууд нь байна уу, байхгүй юу.

Иргэдийн эрхийг хангах чиглэл дээр зохицуулалт хийх шаардлагатай байна уу, үгүй юу. Энэ цахим орчинтой холбоотой асуудлуудаар. Тийм ээ. Гэдэг ийм хоёр санал буюу цахим орчин дахь хувийн мэдээллийн хамгаалалттай холбоотой эрхийн зөрчилтэй холбоотой асуудал, хөдөлмөрийн эрхийн зөрчилтэй холбоотой ийм хоёр асуудлуудыг нэмье гэдэг ийм саналтай байна.

С.Эрдэнэболд: Асуулт дээр Б.Бат-Эрдэнэ гишүүн хоёр санал хэллээ. Тийм ээ.

Хөтөлбөрт тэгвэл Г.Золжаргал зөвлөх тусгаад авчихъя.

О.Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе.

Хүний эрхийн дэд хорооны анхны хурал болж байгаа учраас.

Энэ дэд хороо маань бүтэн нэг жилийн туршид үр дүнтэй сайхан хамтарч ажиллах байх гэж бодож байна.

Миний хувьд асуулт, санал хамтдаа хэлчихье.

Ер нь яах вэ, би сая энэ төлөвлөгөөтэй танилцлаа. Нэлээн олон арга хэмжээг төлөвлөж байгаа юм байна.

Тэгэхээр Хүний эрхийн дэд хорооны чиг үүрэг юу билээ. Түүний хүрээнд бид ажлаа яаж төлөвлөх билээ гэдгээ хармаар юм шиг байгаа юм.

Тэгээд харахаар нэгдүгээрт мэдээж хүний эрхийг хангахтай холбоотой хангах механизм маань яг сайн ажиллаж байна уу? Төлөвлөгөөнд орсны дараа дэд хороо Хүний эрхийн комисстой, бусад байгууллагуудтай яаж ажиллах вэ гэдэг асуудал байгаа. Тийм ээ.

Тэгэхээр хүний эрхийг хангах тэр асуудлаа яаж сайжруулах вэ?

Хоёрдугаарт, манай Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлэг дээр заасан 18 хүний эрхийн зүйл, заалт байгаа. Тийм ээ. Энэ дээр яг тулгамдаж байгаа асуудлууд нь юу байна? Үүнийг ахиц дэвшил гарахын тулд бид юу хийх вэ гэдэг асуудал дээр тулгамдаж байгаа зүйлээсээ харвал зүгээр юм уу гэж хувь хүний хувьд бодож байгаа юм.

Тэгээд эхний асуудал дээр болохоор уг нь Д.Цогтбаатар гишүүн байсан бол Олон Улсын Парламентын Холбооны хүний эрхийн экспертүүд Монгол Улсын парламенттай хамтарч хүний эрхийн нөгөө “self assessment” буюу “өөрийн дүгнэлт, шинжилгээ” хийгээд энэ дээр зөвлөмжүүд хүргүүлсэн байгаа.

Тэгээд энэ зөвлөмж дээрээ жишээлбэл “UPR” буюу Монгол Улс дээр “Universal Periodic Review” гэж хийдэг. Тийм ээ. Хүний эрхийн нөхцөл байдал дээр үүнийг хийгээд өгөхөөр парламентчид буюу хууль тогтоогчид нь яг үнэндээ яг ямар дүгнэлт гараад ямар зөвлөмжүүд гарсныг мэддэггүй юм байна.

Тэгэхээр ядаж НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс “UPR” гаргаад, хяналт шалгалт явуулаад зөвлөмж өгөхөөр энэ дээрээ анхаарах ёстой юм байна шүү гэдгээ Хүний эрхийн дэд хороо өөрөө базаж аваад парламент хууль тогтоох, бодлого тогтоох гаргах юун дээрээ парламентчдадаа мэдээллийг өгдөг энэ механизмыг бүрдүүлбэл сайн байна гэсэн жишээлбэл нэг зөвлөмж гарсан байгаа.

Тэгэхээр энэ ажлын хэсгийн төлөвлөгөө гаргахдаа тэр Олон Улсын Парламентын Холбооны хүний эрхийн экспертүүдээс өгсөн зөвлөмжүүдийг Та бүхэн харсан болов уу?

Зарим нь хэрэгжээд явж байгаа, зарим нь хэрэгжүүлж эхлээгүй юмнууд байгаа юм байна гэж би харсан. Нэгдүгээрт үүнийг асууя.

Хоёрдугаарт, энэ хууль юунуудыг харахаар зарим нь одоо жишээ нь Хүний эрхийн дэд хорооны хийх ёстой ажил уу, тэр нэвтрүүлгийн цагтай байхыг дэд хорооны хувиар бид хийх ёстой юм уу, эсвэл уялдаа холбоог хангах үүднээс юу гэдэг юм Хүний эрхийн комисстоо бид өгөөд, бид яг бодлогын хүрээнд ямар дэмжлэг үзүүлэх вэ гэдгээрээ явах ёстой юу гэдэг ийм асуулт байна л даа.

Тэгэхгүй бол ингээд бодлогын ажил санал, дүгнэлт гаргана. Энэ дээр холбогдох юм хийнэ гэххээд дээр нь дахиад хэрэгжүүлэлтийн ажил руу ороод байгаа болохоор нэг бол ялгаж үзмээр юм болов уу л гэж хараад байна.

Тэгээд Хүний эрхийн комиссоос өгч байгаа яг тулгамдсан асуудал, эсвэл олон улсын байгууллагуудаас гаргаж байгаа Монгол Улсад тулгамдаж байгаа хүний эрхийн асуудлууд дээрээ энэ асуудал ийм байгаа учраас бид ийм ахиц

дэвшил гарахын тулд ингэж байна гэдэг ч.../минут дуусав/

С.Эрдэнэболд: Микрoфон нэмээрэй. 1 минут.

О.Номинчимэг: Жишээлбэл, Монгол Улсын иргэдийн шударга шүүхээр шүүлгэх эрх хэрхэн хангагдаж байна гэдгийнхээ доор жишээлбэл түрүүний эрүүдэн шүүлттэй холбоотой хилс хэргээр орсон, гарч ирээд нөхөн төлбөрөө авч чадахгүй байгаа, авсан ч маш багаар авч байгаа. Сая сошиалаар яваад байсан. 15 жил хилс хэргээр орчхоод гарч ирсэн чинь 50-хан сая төгрөг өгсөн гээд. Тийм ээ.

Энэ мэт асуудлуудыгаа оруулбал яасан юм бэ?

Мэдээж хүүхдийн эрхийн асуудал бол орох ёстой. Энэ бол илүү хүүхдийн эрх гэдэг утгаараа тусдаа байна байх.

Тэгэхээр энэ дээр ямар хүний эрхийн асуудлыг нь энэ удаадаа нэг жилдээ илүү анхааръя гэдэг нь яагаад орж ирсэн гэдэг дээр л цөмөөрөө Хүний эрхийн комисс, олон улсын байгууллагуудаас өгсөн зөвлөмж нь яг энэ дээрээ тулгамдаад байна гэдэг асуудал.

Тэгээд тулгамдаад байна гэдэг асуудлаас чинь зарим нь Их Хурлын даргын ажлын хэсгээр гарчихсан байгаа.

Жишээ нь, хэвлэл мэдээлэлтэй холбоотой ажлын хэсэг бол Ч.Лодойсамбуу гишүүнээр ахлуулаад гарчихсан байгаа.

Эрүүдэн шүүхтэй холбоотой асуудал Г.Тэмүүжин гишүүнээр ажлын хэсэг ахалчихсан байгаа.

Эд нартайгаа яаж уялдах юм
гэдгээ цөмөөрөө нэг
ярилцчихвал.../минут дуусав/

С.Эрдэнэболд: Асуулт санал
давхацсан. Тийм ээ.

Эхнийх нь ер нь Хүний эрхийн дэд
хорооны чиг үүрэг бол маш ойлгомжтой
байгаа.

Улсын Их Хурлын тухай хууль
дээрээ байж байгаа. Бид энэ хүрээнд ер
нь явуулна.

Хоёрдугаарт нь, бусад
байгууллагуудтай яаж ажиллах вэ гэж
байгаа дээр нь 11 сарын 04-нд Хүний
эрхийн Үндэсний Комисс дээр бид яг
очоод нөгөө 7 цаг ажиллахаар бүр
хөтөлбөрт тавьчихсан байгаа байхгүй юу.
11.00 цагаас 18.00 цагийн хооронд.

7 гишүүнтэй нэг бүрчилж ажиллая
гэж байгаа юм. Бүх асуудлуудыг нь,
цаана нь байгаа судалгаанууд, тэнд
байгаа шийдэгдээгүй асуудлууд гээд маш
олон асуудлууд байгаа юм билээ.

Үндсэндээ Хүний эрхийн
Үндэсний Комисс Хууль зүйн байнгын
хороо болон манай Хүний эрхийн дэд
хорооноос энэ энэ асуудлууд дээр
анхаараад өгөөч ээ гэдэг ийм хүсэлтээ
ярьсан.

Тэрийгээ бичгээр бэлдээд бид нарт
танилцуулъя гэж байгаа юм. Нэг.

Мөн одоо жишээлбэл 11 сарын 05-
ны өдөр Amnesty International-ынхантай
уулзах гэж байгаа юм.

Тэгэхээр ойрын хугацаанд яг энэ
судалгаа шинжилгээг нэгдсэн нэг
цонхоор харах юм хийх гээд байгаа юм.

Тэр утгаараа бид өнгөрсөн
хугацаанд Хүний эрхийн дэд
хороонуудыг хийж байсан ажлыг шүүж
үзэхээр бас яг ингээд нэг инерцээр нь урд
нь цааш нь аваад явчих барьж авах
хөтөлбөр ховор байсан учраас бид энэ
дээр нь ний нуугүй хэлэхэд жоохон шинэ
маягийн юм бүтээх л болчхоод байгаа юм
л даа.

Тулгамдаж байгаа зүйлүүд гээд та
яг зөв хэлж байна. Жишээлбэл, ийм
асуудал байгаад байгаа юм.

Их Хурлын даргын захирамжаар
хүний эрхэд нийцсэн орон байртай болох
тухай ажлын хэсэг гээд байгуулчихсан
байх жишээтэй.

Тэгэхээр утааны асуудал, эрүүл
мэндийн дам хохирол гэдэг маань эрүүл,
аюулгүй орчинд амьдрах иргэний эрх
зөрчигдөж байгаатай холбогдож үүсэж
байгаа юу гэдэг дээр маш тодорхой
судалгаанууд тоо баримтууд хэрэгтэй.

Энэ дээр бид баримжаагаар
популист байдлаар ярьж болохгүй байгаа
учраас ер нь ойрын нэг сарын дотор
холбогдох бүх судалгаануудыг л сорж
аваад эрэмбэлээд нэгтгээд нэг юу болгоё,
дизайнд оруулъя л гэсэн ийм бодолтой
байгаа.

Мөн Улсын Их Хурлын даргын
захирамжаар гарсан 2024-2028 оны
Монгол Улсын Их Хурлын стратеги
төлөвлөгөө батлах тухай ажлын
хэсгийнхэнтэй 3 удаа уулзсан. Энэ дээр
яг нөгөө “Хүн төвтэй үзэл” гэдэг үзлээ
“Таван тулгуурт бодлого” гээд дизайн
хийгдээд явж байгаа.

Өчигдөр Монгол Ардын намын бүлгийн хурал дээр танилцуулагдсан. Х.Булгантуяа дарга танилцуулсан.

Тэр хөтөлбөр дээр бид яг энэ “Хүн төвтэй үзэл ба хүний эрх” гэдгийг нь яаж нийцүүлэх вэ гэдэг дээр хамтарч ажиллаж байгаа юм.

Тэгэхээр яах вэ, өнөөдрийн миний зорилго бол Хүний эрхийн дэд хорооныхоо гишүүдийг яг энэ ажлууд руу ингэж татан оролцуулж хамтарч хийе гэдэг л ийм зорилттой байгаа.

Ташрамд дурдахад манай Одсүрэнгийн Номинчимэг гишүүн маань сая Олон Улсын Парламентын Холбооны энэ хүний эрхтэй холбоотой том байгууллагын гишүүнээр сонгогдсон.

Энэ бол бид нарт маш том боломж байгаа. Яагаад гэхээр Хүний эрхийн дэд хорооны ажлыг, Хууль зүйн байнгын хорооныхоо ажлыг ч гэсэн олон улсын парламентынхаа тэр зорилго, зорилт, бодлоготой нь уялдуулах тал дээр бид нарт маш том байршлын хүний нөөцийн давуу тал гэж үзэж байгаа.

Тэгээд энэ ташрамд О.Номинчимэг гишүүндээ баяр хүргэж амжилт хүсмээр байна. Баяр хүргэе. /алга ташив/

Тэгэхээр энэ дээр танаас бас хүсэх нь одоо энд чинь зөвхөн дэд хорооны дарга гэнгүүтээ бүгдийг мэддэг биш, яг энэ дэд хороон дотроо үүнийгээ зөв дизайнчлах тал дээр хэдүүлээ хамтраад хамтраад ажиллая.

Эргээд танаас хүсэх нь яг энэ Олон Улсын Парламентын Холбоон дээрээ, тэр дотроо хүний эрх дээр барьж

байгаа бодлого, Монголд өгч байгаа зөвлөмж дээрээсээ аль алиныг нь хэдүүлээ энэ хөтөлбөртөө оруулах вэ?

Энэ бол нэг их алх цохиод л хатуу шийтгэх гэхээсээ илүүтэйгээр хэдүүлээ уян хатан дизайн гаргаад, гол нь нэг жилийн гэхээсээ илүүтэйгээр цаашдаа хэн ч энэ дэд хороонд ямар ч гишүүн 10 жил, 5 жилийн дараа байсан эргэх холбоотой, эргээд үргэлжлэх зөв процесстой байвал зөв юм болов уу гэж бодож байна.

Тэгээд таны саналуудыг хөтөлбөртөө тусгаж аваад явъя гэж бодож байна.

Тэгэхээр яг саяын О.Номинчимэг гишүүний хэлж байгаа шиг, манай Б.Бат-Эрдэнэ гишүүний хэлж байгаа шиг ийм тодорхой саналуудыг нь бид тусгаж аваад уян хатан цааш нь зохицуулалтуудыг нь хийгээд явчихъя гэж бодож байна. Болж байна уу?

Тэгээд одоо энэ дээр хэд хэдэн зүйлүүд нэмэгдэх юм байна. Г.Золжаргал 14, 16 байгаа шүү дээ. Энэ дээрээ түрүүний Б.Бат-Эрдэнэ гишүүний хэлж байгаа тэр хөдөлмөр эрхлэлттэй холбоотой зүйл дээр нь хэдүүлээ энд нь зорилгодоо оруулаад энэ дээр нэг судалгааны байгууллагуудаас лавлагаанууд аваад ер нь яаж ажиллах вэ гэдэг дээр нь нэг зорилт болгоод оруулъя.

Мөн тэр цахим орчинд байгаа хувь хүний мэдээлэлтэй холбоотой асуудал гэдэг дээр нь энэ дээр нь оруулаад явъя.

Тэр шүүхийн шатанд байгаа хэвлэл мэдээлэлтэй холбоотой, зөвхөн Н.Өнөрцэцэгийн кэйсээс гадна бусад кэйсүүд гэдэг дээр нь ч гэсэн энэ дээр нь задлаад тавиад явчихъя.

О.Номинчимэг гишүүний хувьд яг энэ хөтөлбөр дотроо Олон Улсын Парламентын Холбооны яг хүний эрхтэй холбоотой тэр бүтцийн гаргаж ирж байгаа зорилтууд, мөн Монгол Улсад өгч байгаа зөвлөмжүүдийг энэ хөтөлбөртөө бас удирдлага болгоод оруулъя. Тэгэх үү?

Энэ дээр нь Та саналуудаа өгөөд явъя. Тийм.

Тэгээд яах вэ, хүний эрх гэх юм бол бүх салбар луу орж байгаа юм. Жишээлбэл, утаа хүний эрх асуудал гээд маш олон зүйлүүд байгаа юм.

Тэгэхээр үүнийгээ хэдүүлээ бүгдийг нь тавихаасаа илүүтэйгээр системтэй, эрэмбэ дараатай явъя гэж.

Ингээд О.Номинчимэг гишүүний санаа, Б.Ба-Эрдэнэ гишүүний санааг ороод 19, 20 орчим зүйл болж байгаа.

Тэр ард нь тэр хариуцаж ажиллах Улсын Их Хурлын гишүүн гэдэг дээр саналтай хүмүүс байна уу? Та микрофон дээр хэлчих. Д.Цогтбаатар гишүүний микрофоныг өгье. Манайхан.

Манай Байнгын хорооны даргын микрофоныг нээгээрэй.

Д.Цогтбаатар: Баярлалаа. Өнөөдөр шинэ даргатай болоод Хүний эрхийн дэд хороо бүрэн бүрэлдэхүүнээрээ цуглаад ажиллаж эхэлж байгаад баяртай байна.

Тэгээд энд залуу хүн нэлээн идэвхтэй боловсруулсан байгаа төлөвлөгөөний төсөл надад таалагдаж байна. Их ажил хэрэгч юманд бол хандаж байна.

Тэгээд би энэ дээр хоёр зүйл дээр санаа хэлчихмээр байна.

Нэгдүгээрт, энэ 3 дугаар зүйл дээр байна шүү дээ. Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн тус бүрийн үйл ажиллагаатай танилцах, санал, дүгнэлт боловсруулах гэдэг дээрээ томьёоллоо эргэж нэг харах хэрэгтэй.

Яагаад гэвэл Улсын Их Хурлын гишүүд очоод тэд нарын ажлыг хянаад, дүгнээд байдаг тийм хүмүүс эд нар чинь биш. Нөгөө хараат бус байх ёстой байхгүй юу.

Бид очоод ажлыг нь дүгнээд, бид нараар дүн тавиулах гээд байдаг хүмүүс тэд нар чинь биш учраас энэ томьёоллоо. Өөрөөр хэлбэл тэр гишүүн болгоны ажилтай танилцах бол зөв.

Тэд нараас харин бидний зүгт юу юуг анхаарч ажиллах хэрэгтэй гэж санал тавьж байна. Энэ юмнуудыг нь тэмдэглэж аваад. Бид өөрсдийнхөө ажлыг, бидэнд тэд нар чинь яг хүний эрхийн асуудлаараа зөвлөгөө, чиглэл өгөх ёстой хүмүүс байхгүй юу.

Яагаад гэвэл бид харин хүний эрхийг зөрчсөн үйлдэл явуулаад байна уу, үгүй юу гэдгийг чинь хянах эрхтэй нөхдүүд сууж байна шүү дээ.

Тэгэхээр тэр үүднээсээ энэ томьёоллоо нэг харчхаарай.

Энд нэг юун дээр харин ийм юм хэлмээр байна. 11 дээр. Аягүй чухал зүйл байгаа юм.

Хилс хэрэгт хэлмэгдэж, улмаар шүүхээр цагаатгагдсан иргэдийн талаарх судалгаа гаргаж, уулзах, холбогдох санал, дүгнэлт боловсруулах гэж байгаа юм.

Энэ аягүй чухал. Тэгэхдээ үүнийг бид Монгол Улс яаж хийгээд ирсэн гэхээр өнөөг болтол тэр хохирогчдыг нь. Яг ч гэсэн энэ дээр ингээд биччихсэн байгаа байхгүй юу.

Тэр хүмүүстэйгээ уулзаад л, яасан ийсэн санаа оноог нь. Тэд нар чинь аль хэдийн аягүй тодорхой. Бид ингэмээр байна гээд. Тэгээд Цагаатгах комисс ажил хийгээд явчихсан байгаа.

Одоо өөрөө залуу хүн. Энд байгаа гишүүдийг ч гэсэн энэ дээр хэдүүлээ хамтраад нэг юм хий хиймээр байна.

Ийм хилс хэрэг хүнийг хэлмэгдүүлдэг тогтолцоог зогсоолгох хэрэгтэй байна.

Үүнийг зогсоохын тулд хэлмэгдсэн хүмүүсийг нь зөвхөн анхаараад энэ чинь зогсохгүй. Хэлмэгдүүлсэн нөхдүүдийг хариуцлага тооцдог болж байж энэ зогсоно.

Тэгэхээр би энэ дээр ямар санаа хэлэх гэж байна гэхээр хуулийн төсөл боловсруулмаар байгаа юм.

Би урьд нь Цагаатгах комиссын даргад нэг бус удаа хэлж байсан. Өмнөх түүхийн үед хэлмэгдүүлсэн хүмүүсийг бол Монгол Улс тухайн үедээ үүнийг орхиод явъя гээд тохироод ойлголцчихсон юм байна лээ.

Үүнийг хэдүүлээ сөхөж явах тэгвэл шаардлагагүй. Яагаад гэвэл өмнө нь гарчихсан шийдвэр байна шүү дээ.

Одоо харин үүнээс цааш хүнийг Монгол Улсад улс төрийн зорилгоор хэлмэгдүүлэхгүй. Тэгээд хэлмэгдүүлсэн

хүн нас барсан байсан ч хэргийг нь авч хэлэлцдэг байх ёстой.

Яагаад гэвэл хуульчид ингээд байгаа. Нас барсан бол хэрэг дуусах ёстой гээд.

Үгүй, хилс хэрэг дээр бол өөр шүү. Одоо жишээлбэл, хохирогчдыг нас барсан хойно нь ч цагаатгаад байгаа биз дээ.

Тэгвэл хүнийг хилс хэрэгт гүтгээд явуулсан хүмүүсийг тэр шүүгч, прокурор тийм даалгавар өгсөн улс төрчдийг нь хэзээ ч орхидоггүй байх ёстой. Үүнээс хойш.

Тэд нарыг аваад шийтгэхдээ авлигачдад 20 жил өгч байгаа биз дээ.

Тэгэхэд хүнийг хилс хэрэгт гүтгэж, гэр бүлээр нь. Хилс хэрэг гэдэг чинь зүгээр нэг хүн хохироод дуусахгүй, ар гэр, амьдрал бүх юм нь дуусаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр тэр дээр тийм хүмүүсийг 20 жил буюу тэрнээс дээш шийтгэдэг байх ёстой. Ийм хууль оруулмаар байна.

С.Эрдэнэболд: Баярлалаа.

Хууль зүйн байнгын хорооны дарга саналаа хэллээ.

Энэ 3 дээр байгаа зүйлийг нь редакцаар нь засаад явчихъя.

11 дээрх нь хуулийн төсөл боловсруулах. Хэлмэгдүүлсэн хүмүүс дээр хатуу санкцтай хуулийн төсөл боловсруулах гэсэн саналыг нь аваад хэдүүлээ явъя тэгэх үү.

Ингээд хэлэлцэх асуудал дээр нь миний санаа бол редакцтай баталъя гэдэг санаатай байгаа. Редакцтай гэдэг нь болохоор ерөнхий зарчмын хувьд хэдүүлээ баталчхаад, хугацаа алдахгүй дотроо саяын гишүүдийн оруулж байгаа саналуудыг хийгээд.

Тэгээд ажлын 5 хоногийн дотор бид текст дээр нь ажиллаад, боловсруулаад Хүний эрхийн дэд хорооны гишүүддээ дахиад явуулъя тэгэх үү.

Тэгээд дахиж явуулаад Та бүхэн яг санаануудаа дахиад хэлээд тэгээд хэдүүлээ тэрийг нь хурлын биш зүгээр ажлын шугамаар уулзаад нэгтгээд явуулчихъя.

Өнөөдөр миний санаа Д.Цогтбаатар дарга аа, редакцтайгаар хөтөлбөрөө батлаад, ажлаа явуулаад, тэгээд редакц гэдэг дотроо хэдүүлээ үүнийгээ задлаад дэлгэрэнгүй тавиад явъя гэж бодож байна.

Түрүүний О.Номинчимэг гишүүний хэлсэн саналтай холбоотой. Одоо нөгөө Үндэсний олон нийтийн телевиз ч гэдэг юм уу, яг тэр зүйл дээр нь эргэж харъя.

Яах вэ нөгөө Үндэсний олон нийтийн телевиз гээд. Бид бас үүнийг Улсын Их Хурлын Тамгын газартай ярьсан юм.

Улсын Их Хурлын Тамгын газар 50, 60 ажлын хэсэгтэй маш их ачаалалтай байгаа учраас Хүний эрхийн дэд комиссынхон яг та нар өөрсдөө энэ дээрээ санаачилга, контентоо гаргаад явбал сайн байна гэдэг талын юм хэлж байгаа.

Тэгэхээр бид үүнийг хийх тухай асуудал биш.

Тэгэхээр иймэрхүү хүний эрхийн үзэл санааг, хүний эрхийн үнэт зүйлийг ингэж ингэж нийгэмд гаргамаар байна гэдэг ийм л нэг ийм захиалга өгөх гэх юм уу даа. Тийм ээ. Ийм л зүйлийг л бид хамт ярилцъя гэж бодож байгаа.

Тэгээд хэдүүлээ хөтөлбөртэйгөө танилцлаа.

Тэгвэл өөр санал онолтой гишүүн. Тийм. Үг хэлэх гишүүн байна уу? Сая асуулт байсан. Асуулт, санал нь холилдоод явчихсан байгаа.

Улсын Их Хурлын Дэгийн тухай хуулиараа одоо саяын хөтөлбөртэй холбоотой зүйл дээр саналаа хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна.

Тэгэхээр нөгөө М.Нарантуяа-Нара гишүүн та хэлж байсан шүү дээ. Тийм ээ.

6 дээр нь би ахлаад явъя гэж байсан.

Тэгээд гишүүд маань хөтөлбөр батлагдангуут нь араас нь аль аль хэсэг дээр нь би оролцоод явах уу.

Жишээлбэл, Б.Бат-Эрдэнэ гишүүн сая өөрийн санал болгосон зүйлүүд дээрээ ч гэсэн хариуцаад явбал зүгээр байна.

Үүнийг нэг их тийм ажлын хэсэг гэж хүндрүүлэхгүйгээр, нэг их тийм барилдахаасаа таахалзана гэдэг шиг биш уян хатан байдлаар хэдүүлээ мэдээлэл солилцоод явчихъя гэсэн бодолтой байна.

Ингээд тэгвэл Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны Хүний

эрхийн дэд хорооны өнөөдрийн анхдугаар хуралдаанаар 2024-2025 онд хийх ажлын төлөвлөгөөг бид ярилцаад редакцтайгаар баталъя гэдгийг дэмжиж байгаа гишүүд саналаа өгнө үү. /алх цохив/

О.Номинчимэг гишүүн,
Х.Баасанжаргал гишүүн хоёрыг дэмжсэнээр авах нь байна шүү.

Техникийн алдаа заасан гээд протоколд тэмдэглээрэй.

Ингээд бид дэд хорооны зүгээс Хууль зүйн байнгын хорооны даргадаа хэлэх үг байгаа.

Хууль зүйн байнгын хороо маань нэлээн олон орон тоотой юм байна.

Тэгээд одоогийн байдлаар манай Г.Золжаргал ахлах зөвлөх л ганцаараа ажиллаж байгаа юм байна.

Тэгээд референтүүд нь болон нарийн бичгүүд нь бүрдээгүй байгаа юм байна.

Тэгээд та Хууль зүйн байнгын хорооны даргын хувьд ойрын үед орон тоог бүрдүүлж өгөх юм бол бид ажлаа хийгээд явуулах, төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх боломж бүрдэх юм байна гэдгийг танд хүсэлт тавьж байна.

Дэд хорооны гишүүдийн зүгээс нэг.

Ингээд бид бас нэг ажлын долоо хоногийн дараа саяын Их Хурлын гишүүдээс гарсан санаануудыг нэгтгээд эрэмбэлээд редакцыг нь цэгцлээд дэд хорооныхоо гишүүдэд хүргүүлъя.

Ингээд редакцтайгаар батлагдсан учраас эдгээр ажлуудаа хийгээд явъя.

Ингээд эрхэм гишүүд Та бүхэн хуралдаа оролцсонд баярлалаа. Хуралдаан хаасныг мэдэгдэж байна. /алх цохив/

Хуралдаан 45 минут үргэлжилж, 15 цаг 59 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД